



АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 154.

Улаанбаатар хот

Г

Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 193 дугаар тогтоол, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2022-2026 онд хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр”, эмнэлгийн дүрмийн 5.5 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт мөрдөгдөх шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтаар баталсан хөтөлбөрийг байгууллагын хэмжээнд танилцуулж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Захиргаа, санхүү, хүний нөөцийн албаны Хүний нөөцийн менежер /Б.Саранцэцэг/, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, дэмжин ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгч, арга зүйч нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Н.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Ц.БАТБОЛД

